



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/217

Улаанбаатар хот

**Багануур дүүргийн Гүн галуутай  
цогцолбор сургуулийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 31,606,986.10 /гучин нэгэн сая зургаан зуун зургаан мянга есөн зуун наян зургаан төгрөг арван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургууль /З.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургууль /З.Болормаа/-д үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2019 оны 06 сарын  
28 өдрийн А/217 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	5	ш	8722		14,618,428.9	0.0	14,618,428.9	ашиглагдахгүй	устгах
2	Түрээс сурах бичиг	6	ш	7228		14,361,900.2	0.0	14,361,900.2	ашиглагдахгүй	устгах
3	Уран зохиол	6	ш	656		2,626,657.0	0.0	2,626,657.0	ашиглагдахгүй	устгах
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>						<b>31,606,986.1</b>	<b>0.0</b>	<b>31,606,986.1</b>		
Үүнээс: Худалдах хөрөнгө						0.0	0.0	0.0		
Актлах хөрөнгө						31,606,986.1		31,606,986.1		
Татан төвлөрүүлэх хөрөнгө						0.0	0.0	0.0		
Худалдсанаас олох орлого						0.0	0.0	0.0		
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						0.0	0.0	0.0		